



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/297
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа мэдээллийн үндэсний төвийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа мэдээллийн үндэсний төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

B. M

Ц.НАРАНЧИМЭГ



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН СУДАЛГААНЫ ИНСТИТУТИЙН ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар холбогдон уу:**

ТАБ-ын анхүүгийн аудитын газрын
дарга, Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: enhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Н.Золзаяа
Утас: 261885
Цахим хаяг: zolzayan@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Батсайхан
Утас: 260512
Цахимхаяг: Batsaikhann@audit.gov.mn

ТАБ-ын хаяг:
Үндэсний аудитын газар
Байршил: Засгийн газрын IY байр,
Багатойруу, Улаанбаатар-46
Цахим хуудас: www.audit.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
“Баян Сагсай Аудит” ХХК
Утас: 99090188
Цахим хуудас: www.bsaudit.mn
Цахим хаяг: munkhtsetseg@bsaudit.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 3: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйлажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн төсвийн 2016оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 22-нээс 2017 оны 2 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний Аудитийн Газрын САГ-тай 48 дугаар гэрээ байгуулсны үндсэн дээр Баян Сагсай Аудит ХХК-ийн 2-р багийн аудитор Д.Мөнхцэцэг, Д.Бямбажаргал нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланг 2016 оны 1 дүгээр сарын 25-нд Баян Сагсай Аудит ХХК-д 17 дугаар бүхий албан тоотын хамт ирүүлсэн байна.

Аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 22-ноос 2017 оны 2 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, УАГ-аар хянуулан аудитын тайланг 2016 оны 2 дугаар сарын 25-нд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь 2016 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн Засгийн Газрын 55 дугаар тогтоолоор өөрчлөн зохион байгуулагдсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх, хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гэж заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн төсвийн 2016 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

/ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 12-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг эксел програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал зардалд 243.9 сая төгрөгийн санхүүжилт авсанаас 235.2 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 8.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл

ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар тодорхой тусгана. Hudulmug.mn сайт дээр байгууллагын ил тод байдал цэсэн дээр цалингийн зардлаас бусад 5,0 сая төгрөгнөөс дээших төрийн сангаас хийгдсэн бүх гүйлгээг тогтмол байршуулж ирсэн.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 12 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 12 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа./ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 30 хувь, мөнгөн хөрөнгийн 90 хувь, нийт зардлын 80 хувь, нийт хөрөнгийн 85 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлууд байхгүй. Аудитын явцад материаллаг зөрчил илрээгүй.

Дараах материаллаг бус зөрчил илэрсэн байна:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-д заасан “ Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Менежментийн захидлаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримтбичгийг байгууллагын удирдлагаар батлуулах, мөрдөх талаар зөвлөмж хүргүүлсэн.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311 дугаар тогтоолын 1.3-д Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт

тохирсон “ Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”- тай байна гэж заасны дагуу дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллах.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударгаилэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2016 оны жилийн эцсийн тайлан, тодруулга, судалгааны 26 хуудсыг тус тус хавсаргав.



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН СУДАЛГААНЫ ИНСТИТУТИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйл:

Асуудал 1

НБББББ-ийн талаар.....11

2017 оны 2 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: НБББББ-ийн талаар	Тэргүүлэхачхолбогдол №1
-------------------------------------	--------------------------------

ҮАГ-ынажиглалт

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-д заасан “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримтбичгийг байгууллагын удирдлагаар батлуулах, мөрдөх талаар зөвлөмж өгөх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, орлого зарлагын гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх, төсвийг зориулалт бусаар зарцуулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016 оны 12-р сарын 31-р дуусгавар болсон жилийн хувьд

(Төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
1. ХӨРӨНГӨ		
1.1 Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө		
Дансны авлага		
Татвар, НДШ-ийн авлага		
Бусад авлага		
Бараа материал		18,628,540.00
Хангамжийн материал		18,628,540.00
Бичиг хэргийн материал		3,682,817.00
Аж ахуйн материал		814,100.00
Сэлбэг хэрэгсэл		322,000.00
Түлш, шатах тослох материал		1,517,000.00
Бусад хангамжийн материал		12,292,623.00
Бусад эргэлтийн хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгийн дүн		18,628,540.00
1.2 Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө		3,638,764,733.89
Биет хөрөнгө		3,638,764,733.89
Барилга, байгууламж, орон сууц		3,653,226,758.50
Хуримтлагдсан элэгдэл - Барилга		-266,381,117.81
Авто- тээврийн хэрэгсэл		163,377,700.00
Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл		-78,493,587.39
Машин тоног төхөөрөмж (компьютер)		197,474,479.27
Хуримтлагдсан элэгдэл -Тоног төхөөрөмж		-144,665,471.00
Тавилга, аж ахуйн эд хогшил		161,646,189.89
Хуримтлагдсан элэгдэл-Тавилга		-52,971,217.57
Номын фонд		5,551,000.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		3,638,764,733.89
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		3,657,393,273.89
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1 Өр төлбөр		
Дансны өглөг		
Цалингийн өглөг		
Татварын өр		
НДШ-ийн өглөг		
Урьдчилж орсон орлого		
Бусад богино хугацаат өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөрийн дүн		
Урт хугацаат зээл		
Бусад урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөрийн дүн		
Нийт өр төлбөрийн дүн		
2.2 Цэвэр хөрөнгө өмчийн дүн		3,657,393,273.89
Засгийн газрын хувь оролцоо		3,657,393,273.89
Хуримтлагдсан үр дүн		3,657,393,273.89
Тайлант үеийн үр дүн		3,657,393,273.89
ӨР ТӨЛБӨР БА, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН.		3,657,393,273.89
<i>Нэмэлт тодотголдууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно</i>		

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2016 оны 12-р сарын 31-р дуусгавар болсон жилийн хувьд

(Төгрөгөөр)

	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		3,897,483,965.84
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		3,648,597,865.84
Өмчийн орлого		3,648,597,865.84
Төсөв байгууллагын өөрийн орлого		3,648,597,865.84
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		3,648,597,865.84
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		248,886,100.00
Улсын төсвөөс		243,886,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		243,886,100.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		5,000,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,000,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		215,627,879.18
УРСГАЛ ЗАРДАЛ		215,627,879.18
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		198,281,563.86
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		125,221,215.00
Үндсэн цалин		125,221,215.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		13,999,704.91
Тэтгэврийн даатгал		9,007,404.26
Тэтгэмжийн даатгал		1,029,418.88
ҮОМШӨ-ний даатгал		1,252,212.16
Ажилгүйдлийн даатгал		246,424.51
Эрүүл мэндийн даатгал		2,464,245.11
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		26,258,861.00
Гэрэл, цахилгаан		17,473,387.00
Түлш, халаалт		7,873,894.00
Цэвэр, бохир ус		911,580.00
Хангамж, бараа материалын зардал		17,655,485.00
Бичиг хэрэг		4,198,745.00
Тээвэр, шатахуун		2,352,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		7,777,240.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал		332,500.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс		2,995,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал		3,733,600.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		30,000.00
Урсгал засвар		3,703,600.00
Томилолт, зочны зардал		4,623,421.00
Дотоод албан томилолт		4,623,421.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		758,620.00
Даатгалын үйлчилгээ		549,120.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо		37,500.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		172,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		6,030,656.95
Бараа үйлчилгээний бусад зардал		4,510,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		1,520,656.95
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		17,346,315.32
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		8,711,029.32
Төвлөрүүлэх шилжүүлэг		8,711,029.32
Бусад урсгал шилжүүлэг		8,635,286.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		8,635,286.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН		3,681,856,086.66
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛЫН ДҮН		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		3,681,856,086.66
<i>Нэмэлт тодотголүүд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно</i>		

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 12-р сарын 31-р дуусгавар болсон жилийн хувьд

(Төгрөгөөр)

	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		248,886,100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		248,886,100.00
Улсын төсвөөс		243,886,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		243,886,100.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		5,000,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,000,000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		248,886,100.00
УРСГАЛ ЗАРДАЛ		248,886,100.00
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		231,539,784.68
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		143,699,493.91
Үндсэн цалин		143,699,493.91
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		15,863,000.00
Тэтгэврийн даатгал		10,114,450.61
Тэтгэмжийн даатгал		1,180,668.64
ҮОМШӨ-ний даатгал		1,441,274.33
Ажилгүйдлийн даатгал		284,236.95
Эрүүл мэндийн даатгал		2,842,369.47
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		29,879,782.00
Гэрэл, цахилгаан		20,770,013.00
Түлш, халаалт		7,873,894.00
Цэвэр, бохир ус		1,235,875.00
Хангамж, бараа материалын зардал		24,035,167.77
Бичиг хэрэг		7,064,510.00
Тээвэр, шатахуун		3,919,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		8,192,557.77
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал		547,500.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс		4,311,600.00
Нормативт зардал		828,000.00
Нормын хувцас, зөөлөн эдгэл		828,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал		7,342,300.00
Багаж, техник, хэрэгсэл		1,520,800.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		1,702,000.00
Урсгал засвар		4,119,500.00
Томилолт, зочны зардал		4,623,421.00
Дотоод албан томилолт		4,623,421.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		758,620.00
Даатгалын үйлчилгээ		549,120.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо		37,500.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		172,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		4,510,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		4,510,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		17,346,315.32
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		540.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		540.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		8,710,489.32
Төвлөрүүлэх шилжүүлэг		8,710,489.32
Бусад урсгал шилжүүлэг		8,635,286.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		8,635,286.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
<i>Нэмэлт тодотгодууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салигүй хэсэг болно</i>		

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2016 оны 12-р сарын 31-р дуусгавар болсон жилийн хувьд

(Төгрөгөөр)

	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
Үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(24,462,812.77)	(24,462,812.77)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			(24,462,812.77)	(24,462,812.77)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			3,681,856,086.66	3,681,856,086.66
Үлдэгдэл			3,657,393,273.89	3,657,393,273.89
<i>Нэмэлт тодотголдууд нь эдгээр санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно</i>				